

# "ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар №. 01

Улаанбаатар хот


Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн  
ТОГТООХ нь:

1. "Дорнод бусийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн 2022  
оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг "Хангалттай" гэж үнэлсэн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.

2. Компанийн 2023 оны зорилтот түвшинг биелүүлэх, өртөг зардлыг бууруулах,  
үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү, төлбөрийн чадварыг сайжруулах,  
аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг  
Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ



**"ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар № 02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн  
ажлын тайлангийн тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтыг үндэслэн  
ТОГТООХ нь:

1.“Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааг “Хангалттай” гэж үзсүгэй.

2. Компанийн тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах,  
үйл ажиллагааг эрчимжүүлэх хариуцлагатай, үр дүнтэй, санаачилгатай ажиллахыг  
Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Н.ТАВИНБЭХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯРЭРДЭНЭ

**"ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар № 02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн  
ажлын тайлангийн тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтыг үндэслэн  
ТОГТООХ нь:

1.“Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааг “Хангалттай” гэж үзсүгэй.

2.Компанийн тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах,  
үйл ажиллагааг эрчимжүүлэх хариуцлагатай, үр дүнтэй, санаачилгатай ажиллахыг  
Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:




Н.ТАВИНБЭХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯРЭРДЭНЭ

"ДБЭХС" ТӨХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН 2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28.-  
НЫ ӨДРИЙН 07 ДУГААР ТОГТООЛЫН  
ХАВСРАЛТ



"ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын нэр төрөл	2023 оны төлөвлөгөө /мян.төг/
1	ТУЗ-ийн бүрэлдэхүүн	10
	ТУЗ-ийн даргын цалин	13,000.0
	-ТУЗ-ийн гишүүний цалин	89,600.0
	-ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин	9,000.0
2	Цалингийн сан	111,600.0
3	НДШ	16,182.0
4	Томилолтын зардал /шатахуун/	10,237.0
5	Бичиг хэрэг	180.0
6	Хурал зохион байгуулах зардал	660.0
	ДҮН	138,859.0

**"ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 28-дөр

Дугаар №09

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны  
ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, 47.1.1-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорнод бусийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангаар алдагдалтай ажилласан бөгөөд компанийн эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр дутагдаж төлбөрийн чадвар буурах тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Н.ТАВИНБЭХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

# "ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар № 05

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой  
нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 84 дүгээр зүйлийн 84.4.2 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх түр журам"-ын 2.7, 2.8, 2.9 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/77 дугаар тушаалаар томилогдсон Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Дорнод бусийн эрчим хүчний систем" Төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг 74 оноор "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатайгаар байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад удирдамж болгосугай.

3. Засгийн газраас дэвшүүлсэн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн өртөг зардлыг бууруулах, орлогын төлөвлөгөөг биелүүлэх, өр, авлагыг барагдуулах, үр ашгийг дээшлүүлэх, талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



# "ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар №.06

Улаанбаатар хот

Компанийн эздиийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэх,  
дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.16 дахь заалт, "Дорнод бусийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Дорнод бусийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хоёрдугаар хавсралтад заасан 220,000,000.68 /Хоёр зуун хорин сая төгрөг жаран найман мөнгө / төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр компанийн эздиийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д зөвшөөрсүгэй.

3."Дорнод бусийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 03 дугаар зүйлийн 3.1 дэх заалтад "нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 513 702 195 ширхэг энгийн хувьцаатай" гэснийг 515 902 195 ширхэг энгийн хувьцаатай" гэж өөрчилсүгэй.

4.Компанийн дүрэм болон эздиийн өмч дэх төрийн өмчийн дүнд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг "Дорнод бусийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Н.ТАВИНБЭХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

“ДБЭХС” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
хурлын 2023 оны 05 дүгээр сарын 12-ны  
өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр  
хавсралт



## “ДБЭХС” ТӨХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

1.“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7, 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмэх: Үүнд:

1. “7.3.18.Компанийн дотоод аудитын нэгжийн ахлах, дотоод аудиторыг томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

7.3.19.Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бусад асуудал.

7.17.2.Дотоод аудиторыг томилох, чөлөөлөх, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах” гэж нэмэх;

3. “9.5.Авлигатай тэмцэх газраар хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянуулах Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцэн томилогддог албан тушаалтан болон компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага (салбар, хэлтэс, алба, цех)-ын албан тушаал, ажлын байрны жагсаалтыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.” гэж нэмэх;

2.“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 1,8,10,12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай өөрчлөлт оруулах. Үүнд:

2.1. Компанийн дүрмийн 1.4 дэх хэсгийн “Компани нь 100 хувь /хувьцааг нь төр эзэмшдэг/ төрийн өмчит хувьцаат компани мөн бөгөөд нийт хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшинэ.” гэснийг “Компани нь 100 хувь /хувьцааг нь төр эзэмшдэг/ төрийн өмчит хувьцаат компани мөн бөгөөд нийт хувьцааны 66 хувийг Эрчим хүчний яам, 34 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус хэрэгжүүлнэ.” гэж өөрчлөх;

2.2. Компанийн дүрмийн 8.8.1 дэх заалтын “Менежментийн ур чадвартай, эрчим хүчний мэргэжилтэй, дээд боловсролтой, 2-оос доошгүй жил удирдах албан тушаалд ажил гүйцэтгэж байсан, удирдлагын зохих дадлага туршлагатай байх;” гэснийг “Менежментийн ур чадвартай, 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажил гүйцэтгэж байсан, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, удирдлагын зохих дадлага туршлагатай, эрчим хүчний инженер /0713 цахилгаан, эрчим хүч/, эсхүл менежмент ба удирдахуй /0413/ чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх” гэж өөрчлөх;

2.3.Компанийн дүрмийн 10.5 дах хэсгийг “Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.” гэснийг “Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитын нэгж хэрэгжүүлнэ.” гэж өөрчлөх;

2.4.Компанийн дүрмийн 10.6 дах хэсгийг “Дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.” гэснийг “Дотоод аудитор нь дараах шаардлагыг хангасан байна:

10.6.1.Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй;

10.6.2.Бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй;

10.6.3.Мэргэшсэн nyaгтлан бодогч;


10.6.4.Тухайн мэргэжлээрээ тав болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх.” гэж өөрчлөх;

2.5.Компанийн дүрмийн 10.7 дах хэсгийг “Дотоод хяналтын алба компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, энэхүү дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллана.” гэснийг компанийн дотоод аудитын нэгжийн ажиллах журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.” гэж өөрчлөх;

2.6.Компанийн дүрмийн 10.8 дах хэсгийг “Дотоод хяналтын алба нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, мэдээлэх үүрэгтэй.” гэснийг дотоод аудитор нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд аудит, хяналт шалгарт хийх, аудитын тайлан, үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороогоор хэлэлцүүлэх, холбогдох аудитын дүгнэлт, зөвлөмж, үүрэг даалгаврыг гүйцэтгэх удирдлагад өгөх, биелэлтийг хангуулах, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж ажиллана.” гэж өөрчлөх;

2.7.Компанийн дүрмийн 12.2 дах хэсгийг “Компанийн ерөнхий nyaгтлан бодогч нь мэргэшсэн nyaгтлан бодогч байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө.” гэснийг Компанийн ерөнхий nyaгтлан бодогч нь мэргэшсэн nyaгтлан бодогч байх бөгөөд түүнийг Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө.” гэж өөрчлөх;

“ДБЭХС” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
хурлын 2023 оны 05 дүгээр сарын 02-  
ны өдрийн 06 дугаар тогтоолын  
хоёрдугаар хавсралт



**“ДБЭХС” ТӨХК-ийн эздийн өмч дэх төрийн өмчийн дүнгийн өөрчлөлт**

д/д	Төрийн өмчийн дүн	Тогтоол шийдвэрийн дугаар	Бүртгэлийн дүн
1	2022 оны 01 дүгээр сарын 01-нээрх төрийн өмчийн дүн		51,370,219,512.43
2	Нэмэгдсэн: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймгийн Цагаан- Овоо сумын гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамж, техникийн боломж бүрдүүлэх ажлын хүрээн бий болсон 0.4 кВ-ын ЦДАШ, тоолуурын самбар, тоолуур, кабель шугам	ТӨБЗГ-ын 2022 оны 10 дугаар сарын 20ны өдрийн 438 дугаар тогтоол	220,000,000.68
3	2022 оны 12 дугаар сарын 31-нээрх төрийн өмчийн дүн		51,590,219,513.11
4	Нэрлэсэн үнэ		100
5	Хувьцааны тоо		<b>515,902,195</b>